

USC 0802A:2022

НОГООН БАЙГУУЛАМЖ




Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй
ажиллагааны удирдамж

НОГООН БАЙГУУЛАМЖ

Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй
ажиллагааны удирдамж

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 20-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ.....	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томъёоны тайлбар	5
4. Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах шаардлага.....	5
5. Цэцэрлэгчийн ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага ..	7
6. Осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж.....	16
7. Цэцэрлэгчийн мөрдөх аюулгүй ажиллагааны заавар.....	18
8. Цэцэрлэгчийн ажлын нөхцөл.....	24
9. Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны удирдамжийн шалгуур үзүүлэлт ..	26
Ашигласан материал	27
Хавсралт 2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тэмдэг	28
Хавсралт 2 Цэцэрлэгчинд учирч болзошгүй осол, гэмтэл	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хамгаалалтын малгай (Жишээ зураг).....	7
Зураг 2. Нүүрний хамгаалалт (Жишээ зураг).....	7
Зураг 3. Нүдний шил (Жишээ зураг).....	7
Зураг 4. Хамгаалалтын бээлий (Жишээ зураг).....	8
Зураг 5. Ажлын хувцас (Жишээ зураг).....	8
Зураг 6. Ажлын өвлийн хувцас (Жишээ зураг).....	8
Зураг 7. Хамгаалалтын гутал (Жишээ зураг).....	8
Зураг 8. Хамгаалалтын усны гутал (Жишээ зураг).....	9
Зураг 9. Гутлын нэмэлт улавч (Жишээ зураг)	9
Зураг 10. Ус нэвтрүүлдэггүй хувцас (Жишээ зураг).....	9
Зураг 11. Химийн бодист тэсвэртэй бээлий (Жишээ зураг).....	9
Зураг 12. Хошуувч (Жишээ зураг).....	9
Зураг 13. Хөдөлмөр хамгааллын хантааз (Жишээ зураг).....	10
Зураг 14. Шилбэний хамгаалалт (Жишээ зураг).....	10
Зураг 15. Гарын хамгаалалт (Жишээ зураг).....	10
Зураг 16. Хөлийн хамгаалалт (Жишээ зураг).....	10
Зураг 17. Өвлийн хувцасны загвар (Жишээ зураг).....	12
Зураг 18. Цэцэрлэгчийн зуны хувцасны хийц (Жишээ зураг).....	12
Зураг 19. Тусгай зориулалтын хувцас (Жишээ зураг)	14
Зураг 20. Цэцэрлэгжүүлэлтийн хөдөлмөр хамгааллын гутал (Жишээ зураг).....	15
Зураг 21. Анхны тусламжийн хайрцаг (Жишээ зураг)	16
Зураг 22. Анхны тусламжийн хэрэгсэл (Жишээ зураг)	16

Зураг 23. Артерийн судасны цус алдалтын үед чангалуур тавьж боох (Жишээ зураг)	17
Зураг 24. Үе мөчний яс хугараагүй боловч шархнаас цус алдаж байх үеийн боолт хийх арга (Жишээ зураг)	17
Зураг 25. Залгиурт тээглэсэн гаднын биетийг авах арга (Жишээ зураг).....	17
Зураг 26. Амьсгалын дээд замд ус орсон үед авах арга (Жишээ зураг).....	17
Зураг 27. Амнаас аманд зохиомол амьсгал хийх арга (Жишээ зураг).....	17
Зураг 28. Цэцэрлэгчийн сууж ажил гүйцэтгэхэд ашиглагдах сандал (Жишээ зураг).....	21
Зураг 29. Мод сөөгийг хэлбэржүүлэх танах (Жишээ зураг)	21
Зураг 30. Цэвэрлэгээний огтлол (Жишээ зураг)	21
Зураг 31. Гар багаж ашиглах үед (Жишээ зураг)	22
Зураг 32. Багажийг ирлэх, ир солих (Жишээ зураг).....	22
Зураг 33. Хурц ирмэг, иртэй багаж, хэрэгслийн (Жишээ зураг)	23
Зураг 34. Багажийг үүрч, түрж явах (Жишээ зураг)	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл	7
Хүснэгт 2. Ажлын хувцасны өнгө	11
Хүснэгт 3. Хувцасны хэмжээний хүснэгт	13
Хүснэгт 4. Эрэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа.....	13
Хүснэгт 5. Эмэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа	13
Хүснэгт 6. Хаврын улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл	24
Хүснэгт 7. Зуны улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл	25
Хүснэгт 8. Намрын улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл	25
Хүснэгт 9. Өвлийн улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл	26
Хүснэгт 10. Цэцэрлэгчийн хөдөлмөр, аюулгүй ажиллагааны шалгуур үзүүлэлт	26



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

**Ногоон байгууламжид хамаарах
хотын стандартыг батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Ногоон байгууламж бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS0801A:2022 “Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн удирдамж” хотын стандарт

1.2. UCS0802C:2022 “Мод таримал ургамлын төрөл зүйлийн лавлах” хотын стандарт

1.3. UCS0803B:2022 “Ногоон байгууламжийн арчилгаанд тавих шаардлага” хотын стандарт


1.4. UCS0802A:2022 “Цэцэрлэгчийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны удирдамж” хотын стандарт

1.5. UCS0801C:2022 “Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн лавлах” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж. БАТБАЯСГАЛАН

1110100307

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 20
дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

НОГООН БАЙГУУЛАМЖ

USC 0802A:2022 “ЦЭЦЭРЛЭГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг цэцэрлэгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуй нэгж байгууллага дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг хангах ба өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- MNS 4931-2000 Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага;
- MNS 5621-2006 Толгой хамгаалах хэрэгсэл дуулга;
- MNS 5622-2006 Гарын хамгаалалт (бээлий);
- MNS 5623-2006 Хөлийн хамгаалалт ажлын тусгай гутал;
- MNS 13688-2000 Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Дотрын материал - гэж гадуур хувцсыг өмсөх, тайлахад хялбар байлгах, дотор талд өмссөн хувцастай барьцалдахгүй байлгах зориулалт бүхий материал;

Атлас нэхээс - гэж гөлгөр гадаргуу үүсгэн нэхсэн даавуу (дотрын материал);

Сарж нэхээс - гэж диагональ хээ үүсгэн нэхсэн даавуу.

4. ЦЭЦЭРЛЭГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ШААРДЛАГА

Ажил олгогч нь албан ажилчдын эрхлэх ажил үүргээс хамааруулан аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулна.

4.1. Шинээр ажилтан бэлтгэх үеийн сургалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

- 4.1.1. Шинээр ажилтан бэлтгэх үеийн сургалтыг эрх бүхий этгээдээс баталсан удирдамж хөтөлбөрийн дагуу зохион байгуулна;
- 4.1.2. Шинээр ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын холбогдох шаардлагыг заавал тусгана;
- 4.1.3. Шинээр ажилтан бэлтгэх үеийн аюулгүй ажиллагааны сургалтыг нарийн мэргэшсэн ажилтан, мэргэжлийн багш удирдаж хийлгэнэ;

- 4.1.4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар олсон мэдлэгийг тогтоосон журмын дагуу шалгах ба тэнцээгүй хүмүүсийг давтан сургалтад хамруулж дахин шалгалт авна.
- 4.2. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажлын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг байгууллага дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:
- 4.2.1. **Урьдчилсан зааварчилгаа** - Байгууллагын өвөрмөц онцлог, дотоод дүрэм, техникийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин (МШӨ), хурц хордлого, үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг болно;
- 4.2.2. **Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа** - Ажлын байр өөрчлөгдөх үед, ажилд шинээр орсон болон үйлдвэрлэлийн дадлага хийхээр ирсэн хүмүүст өгнө. Ажлын бүх үе шатуудад хийгдэх, ашиглагдах, багаж тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага, ашиглалт, осолдогчдод үзүүлэх анхны тусламж үзүүлэх зэрэг зааварчилгаануудыг өгнө. Зааварчилгааг байгууллагын ХАБЭА-н мэргэжилтэн болон тухайн ажлын байрыг хариуцсан инженер, удирдлага батлагдсан журмаар өгнө;
- 4.2.3. **Давтан зааварчилгаа** - Давтан зааварчилгааг ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны агуулгаар өгнө. Энэ зааварчилгаа нь гурван хэлбэртэй байна. Үүнд:
- ээлжит (улиралд нэгээс доошгүй удаа өгнө);
 - ээлжит бус (шинэ технологи нэвтрэх, хөдөлмөрийн нөхцөлд өөрчлөгдөх, байгууллагын журамд өөрчлөлт орсон, ажилтан тухайн төрлийн ажлыг удаан хугацааны дараа дахин гүйцэтгэх тохиолдолд);
 - ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа (ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө бичгээр өгч бүртгэлийн журнал хөтөлнө).
- 4.3. Зааварчилгааны хөтөлбөр, хичээлийн сэдвийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан боловсруулж байгууллагын удирдлага батална.
- 4.4. Өргөх, тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмж, химийн хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэж байгаа зэрэг хөдөлмөрийн онцгой нөхцөлд ажиллах ажилтныг мэргэжлийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай хөтөлбөрөөр сургаж, үнэмлэх олгох ба зохих эрх аваагүй ажилтныг ажиллуулахыг хориглоно.
- 4.5. Сургалтыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу тухайн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгж, ажилтан зохион байгуулна.
- 4.6. Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн аюулгүй ажиллагааны сургалтад техникч, цэцэрлэгчин ажилтан нарыг улиралд нэг удаа, инженер, удирдах ажилтныг жилд нэгээс доошгүй удаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтад хамруулна.

5. ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН ХУВЦАС, ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1. Эргономик шаардлага

Хөдөлгөөн хийх үед хүний биеийн чөлөөт хөдөлгөөнийг хангах, өмсөх тайлахад хялбар, гадаад орчны нөлөөнөөс хамгаалах зэргийг нэгтгэсэн цогц шаардлага. Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл дараах шаардлагыг хангасан байна.

5.1.1. Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага MNS13688:2000” Монгол Улсын стандартын шаардлагыг ханган бат бөх чанартай хийгдсэн байна.

5.1.2. Ажлын тусгай хувцас нь жилийн бүх улиралд өмсөх хоёр төрөл байна. Өвлийн улиралд өмсөх хувцас нь -40°C хүртэлх хүйтэнд өмсөхөөр зориулагдсан дулаалга, доторлогоотой байна.





5.1.3. Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйл, сөрөг нөлөөллийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байна.






5.2. Цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл

5.2.1. Цэцэрлэгчийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, тэдгээрийн ашиглалтын хугацааг байгууллага нь Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу дотоод журамдаа тусгана.

Хүснэгт 1.Цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
 Зураг 1.Хамгаалалтын малгай (Жишээ зураг)	Хамгаалалтын малгай нь толгой дээр аливаа гаднын биет унах, эсхүл шидэгдэж ирэхээс хамгаалах зориулалттай юм.	<ul style="list-style-type: none"> ➤ Хэрэглэхээс өмнө бүрэн бүтэн байдлыг шалгана. ➤ Зориулалтын дагуу хэрэглэнэ. ➤ Ургамал хамгаалах химийн бодистой харьцаж ажиллах үед резин юм уу хуванцар эдээр хийсэн малгай өмсөх шаардлагатай.
 Зураг 2.Нүүрний хамгаалалт (Жишээ зураг)	Цахилгаан хөрөөгөөр мод хөрөөдөх, хэлбэржүүлэх, зүлэг хадах явцад ургамлын хаягдал, чулуу үсрэх аюулаас нүүрийг хамгаална.	<ul style="list-style-type: none"> ➤ Хэрэглэхээс өмнө бүрэн бүтэн байдлыг шалгана. ➤ Зориулалтын дагуу хэрэглэнэ. ➤ Гүйцэтгэх ажлын нөхцөлд тохирсон байна.
 Зураг 3.Нүдний шил (Жишээ зураг)	Нүдийг гадны нөхцөлөөс үүсэж болзошгүй ослоос хамгаална.	

 <p><i>Зураг 4.Хамгаалалтын бээлий (Жишээ зураг)</i></p>	<p>Ажлын нөхцөлөөс үүсэж болзошгүй гэмтэл, өвчлөлт, харшил зэргээс хамгаалж, ажилд тохируулж өмсөнө.</p> <p>Чанарын баталгаажуулалт, KWF-ийн дүрс хяналтын дүрс тавьж өгсөн бээлийг ашиглана.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бээлий нь хийж буй үйл ажиллагаа бүрд тохирсон байна. ➤ Хэрэглэхээс өмнө бүрэн бүтэн байдлыг шалгана. ➤ Бээлийг зориулалтаар нь ашиглахад гарын арьсанд сөрөг нөлөөлөл, цочрол үзүүлэхгүй байна.
 <p><i>Зураг 5.Ажлын хувцас (Жишээ зураг)</i></p>	<p>Орчин үеийн даавуун материалаар хийгдсэн байх.</p> <p>Тухайлбал сунадаг, агааржуулалт сайтай байх. Хажуу талын хармаануудыг болж өгвөл цахилгаантай хийж өгөх. Багаж хэрэгсэл хийх халаастай байна. Өвдөг хамгаалах бэхлэлтэй. Хөлийн дээд хэсэг чийгийн хамгаалалттай. Арчлахад хялбар хурдан хатдаг байх шаардлагатай.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Хүний биед сөрөг нөлөө үзүүлэхгүй материалаар хийгдсэн байна. ➤ Цахилгаанжихгүй. ➤ Хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалж ажлын тусгай хувцасны ашиглалт эдэлгээний хугацаа өөр байна. ➤ Хувийн хамгаалалтын хувцас хэрэгслийг тогтмол хугацаанд шалгаж, шаардлагатай бол шинэчилж, солих арга хэмжээ авна.
 <p><i>Зураг 6.Ажлын өвлийн хувцас (Жишээ зураг)</i></p>	<p>Хүний биеийг хүйтний улиралд хайрахаас сэргийлж, үстэй болон ноосон дотортой байна. Дотор нь салгах зориулалтаар хийгдсэн. Дотрын материал нь хувцсыг өмсөх тайлахад хялбар байна. Дотор нь өмсөж буй хувцастай үрэлт үүсгэхгүй байна.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Цэцэрлэгчин нь улиралд тохирсон дулаан, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангагдана. ➤ Осгох, хөлдөлтийн үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байна.
 <p><i>Зураг 7.Хамгаалалтын гутал (Жишээ зураг)</i></p>	<p>Ажлын нөхцөлөөс шалтгаалж хөлийг зүсэх, хатгах, харшлах, осгох, хөлдөх, норох, бяцрах, цахилгаанжих, халтирах зэрэг аюулаас хамгаална.</p> <p>Улирлын ажилд тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөнө.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Ажлын нөхцөлөөс хамаарч зориулалтын материалаар хийгдсэн, ашиглалтын тэмдэглэгээтэй байна. ➤ HR-халалтаас хамгаалсан-Гутлын ул өндөр температурт тэсвэртэй материалаар хийсэн. ➤ INS-хүйтнээс хамгаалсан-Хүйтэн орчинд ажиллахад зориулагдсан байна.

 <p><i>Зураг 8.Хамгаалалтын усны гутал (Жишээ зураг)</i></p>	<p>Хамгаалалтын зориулалт бүхий усны гутал дээр ус нэвтрүүлэхгүй байх хатуу шаардлага тавьдаг.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Урт хугацаагаар хэрэглэхээс зайлсхийх. ➤ Усны гутал нь синтетик, хиймэл үстэй материалаар хийсэн оймстой, хөлд эвтэйхэн байх шаардлагатай.
 <p><i>Зураг 9.Гутлын нэмэлт улавч (Жишээ зураг)</i></p>	<p>Гутлын гадна талаар углаж хэрэглэнэ. Халтиргаа, гулгаанаас хамгаална. Налуу газарт ажиллах үед хэрэглэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Зориулалтын дагуу зөвхөн шаардлагатай нөхцөлд хэрэглэнэ. ➤ Гутлын хэмжээнд тохируулж хэрэглэнэ.
 <p><i>Зураг 10.Ус нэвтрүүлдэггүй хувцас (Жишээ зураг)</i></p>	<p>Ус, чийг нэвтрүүлэхээс хамгаалах хувцсыг борооны улиралд, ургамлын өвчин хортонтой тэмцэх, мод шохойдох, будах ажлын үед хэрэглэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Урт хугацаагаар хэрэглэхээс зайлсхийх ➤ Ус чийгээс хамгаалах хувцсыг тайлсны дараа биеийн салхи цохихоос хамгаалж, биеийг хуурай алчуураар арчих, дулаан хувцас өмсөх хэрэгтэй. ➤ Химийн бодист тэсвэртэй байх.
 <p><i>Зураг 11.Химийн бодист тэсвэртэй бээлий (Жишээ зураг)</i></p>	<p>Ургамал хамгааллын бодис, найруулах цацах болон бордоо ашиглахад хэрэглэнэ. Химийн бодисыг хэрэглэхдээ биед нэвчихээс хамгаалж, зориулалтын хувцсыг зөв, бүрэн өмссөн байна.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бээлийг үлээж бугуйн хэсгийг атгаж, шахаж бүтэн байдлыг шалгана. ➤ Бээлий шингэн нэвтрэхгүй материалаар хийгдсэн байна. ➤ Шаардлагатай тохиолдолд хөвөн, даавуун, арьсан бээлийн гадуур давхарлаж өмсөнө.
 <p><i>Зураг 12.Хошуувч (Жишээ зураг)</i></p>	<p>Ургамал хамгаалан өвчин хортон, хог ургамалтай тэмцэн хор цацах, тоос шороотой орчинд ажиллах үе шүүлтүүртэй амны хамгаалалт хэрэглэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Хошуувч шүүлтүүртэй байна. ➤ Шүүлтүүрийг ашиглалтын хугацаа дууссан үед солино.

 <p><i>Зураг 13.Хөдөлмөр хамгааллын хантааз (Жишээ зураг)</i></p>	<p>Ажилтныг аюулаас хамгаалах гэрлийн ойлттой хувцас.</p> <p>Онцгой нөхцөлд хэрэглэгдэх хантааз.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Аюулгүй ажиллагааг хангахад зориулагдсан цацруулагчтай байна. ➤ Замын хөдөлгөөнд ойр, өндөрт, үзэгдэх орчин бага, нөхцөлүүдэд ажиллах үед өмсөнө.
 <p><i>Зураг 14.Шилбэний хамгаалалт (Жишээ зураг)</i></p>	<p>Шилбэний хамгаалалт нь зүлэгжүүлэх болон бусад тохижилтын ажилд ажиллах үед хэрэглэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Хөлийн доод хэсгийг хог хаягдал, чулуунаас хамгаалдаг.
 <p><i>Зураг 15.Гарын хамгаалалт (Жишээ зураг)</i></p>	<p>Гарын хамгаалалт нь мод бутыг танаж тайрах, хэлбэржүүлэхэд гарыг өргөс, хатсан мөчир, үзүүртэй ирмэг зэргээс хамгаалах зориулалттай.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бут сөөг танах, тайрах үед гарын шууг гэмтэхээс хамгаална.
 <p><i>Зураг 16.Хөлийн хамгаалалт (Жишээ зураг)</i></p>	<p>Энэ нь хөрөөнөөс хамгаалах хэрэгсэл биш бөгөөд тоос шороо нэвтрэх, гэмтлээс хамгаалах зориулалттай хөлийн хамгаалалт.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бут сөөг танах, тайрах үед хөлийг гэмтэхээс хамгаална.

5.3. Ажлын хувцсанд тавих нэмэлт шаардлага

Хөдөлмөрийн нөхцөлийг харгалзан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага:

- 5.3.1. Ус, тос, масло нэвтрүүлэхгүй байх.
- 5.3.2. Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас, өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх ба хөдөлгөөнд саад болохооргүй байна.
- 5.3.3. Өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх үед хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь шарх, бие барилт үүсгэхгүй байх, бүрдэл хэсгүүд саад болохгүй байна.
- 5.3.4. Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумын түлэгдэлтийн үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.
- 5.3.5. Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцолдохгүй байх.

5.3.6. Өвдөг тохой, өгзөг хэсгээр нэмэлт давхарлагаатай байна.

5.3.7. Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. Оруулгын өнгө саарал байна.

5.4. Тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага

5.4.1. Хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалж ажлын тусгай хувцасны ашиглалт эдэлгээний хугацаа, дулаалга, өнгө өөр байна. Ажлын хувцасны өнгө нь хүснэгт 2-т заасны дагуу байна.

Хүснэгт 2. Ажлын хувцасны өнгө

Мэргэжлийн ангилал	Өвлийн хувцас			Зуны хувцас		
	Хүрэм		Өмд	Хүрэм		Өмд
	Үндсэн	Нэмэлт (оруулга)		Үндсэн	Нэмэлт (оруулга)	
Ажлын хувцас	Хөх	Тодруулагчтай Саарал	Хөх	Ногоон	Тодруулагчтай саарал	Ногоон

5.5. Өвлийн хувцасны загвар

5.5.1. Хүрмийн ззагвар хийц дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- салхи орох, дулаан алдахаас сэргийлсэн байх;
- бүч бүхий малгайтай байх;
- үстэй захтай;
- ханцуйн үзүүрийн дотор талд салхи орохоос хамгаалах зангуу товчоор чангардаг байна;
- бүсэлхийн хэсэгт салхи орохоос хамгаалж дотор талдаа гүйдэг уяатай бүстэй байна;
- далд товчлоостой;
- энгэрийн дээд хэсэгтээ тагтай халаастай, ташаандаа ил халаастай;
- энгэр, ар нуруунд гэрэл ойдог туузан оруулгатай.

5.5.2. Өмдний загвар, хийц дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- нуруугаар салхи орохоос хамгаалах комбинзон, бүсэлхийгээрээ сунаж, агших чөлөөтэй өмсөх резинэн оруулгатай байна. комбинзоны мөр нь уртасгаж, богиносгох зориулалттай резинэн мөртэй, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой өвдгөнд 2 хуниастай байна;
- үндсэн дулаалга болон дотроос салдаг нэмэлт дулаалгатай байна. дулаалгын шуумаг хэсэгт сүлжмэл манжеттай байна. дотроос салдаг дулаалгыг тайлснаар хавар, намрын улиралд өмсөх бололцоотой болно;
- ташааны оёдолд орсон халаастай;
- хоёр хажуу талдаа тагтай ил халаастай;
- шуумаг хэсгийг зангуу нарийсгах боломжтой.



Зураг 17. Өвлийн хувцасны загвар (Жишээ зураг)

5.6. Зуны хувцасны загвар

5.6.1. Ажлын цамц нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- эргэсэн хэвтээ, сорочкан захтай, ханцуй нь манжеттай байна;
- энгэрийн дээд хөндлөн оруулгатай;
- залгаа ханцуйтай;
- далд цахилгаан товчтой;
- энгэртээ ил халаастай халаас нь даравчтай байхаас гадна ташаандаа далд ташуу 2 халаастай байна;
- сугандаа агааржуулагчтай байна.

5.6.2. Өмд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- өвдгөнд хуниастай байх;
- ташааны оёдолд орсон халаастай;
- сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой;
- хажуу талд тагтай халаастай;
- шуумаг хэсгийг нарийсгах боломжтой.



Зураг 18. Цэцэрлэгчийн зуны хувцасны хийц (Жишээ зураг)

5.7. Ажлын хувцасны материалд тавих шаардлага

5.7.1. MNS 4010:2009, MNS 1835-6:2007, MNS ISO9237, MNS 1835-7:2007, ISO:12947, MNS 1835-3:2007, MNS 4010-2009, MNS 4010-97, MNS 1835- 5:2007, MNS 1835-9:2007, MNS 4072-88, MNS 4069-88, MNS 4070-88 стандартуудын дагуу байна.

5.8. Ажлын хувцасны хэмжээ

5.8.1. Ажлын хувцасны хэмжээг хүний өндөр, цээж болон бэлхүүсний тойргийн уртаар тодорхойлно.

5.8.2. Ажлын хувцасны хэмжээг тэмдэглэх жишээг дараах байдлаар хүснэгт 3.-т үзүүлэв.

Хүснэгт 3.Хувцасны хэмжээний хүснэгт

Биеийн өндөр (рост)	Биеийн өндрийн хэмжээний зөвшөөрөх нөхцөл, см	Цээжний тойргийн хэмжээ (размер)	Цээжний тойргийн Хэмжээний зөвшөөрөх нөхцөл, см
146,152	146....155	88, 92	86 ... 94
158,164	155....167	96, 100	94.... 102
170, 176	167....179	104, 108	102...110
182, 188	179....191	112, 116	110....118
		120, 124	118... 126
		128, 132	126....134

Хүснэгт 4.Эрэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа

Эрэгтэй хүний хэвийн хэмжээ	Хэвийн размер	Том размер
	40 42 44 46 48 50 52 54	56 58 60 62 64
Цээжний	80 84 88 92 96 100 104 108	112 116 120 124 128
Өндрийн	158 164 168 171 177 180 182	184 186 186 187 187
Бэлхүүсний	68 72 76 80 84 88 92 98	102 108 112 118 122
Гарын урт	56 57 58 59 60 61 62 63	64 65 66 67 68
Хөлийн урт	71 73 74 76 78 79 80 81	82 83 83 83 83

Хүснэгт 5.Эмэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа

Эмэгтэй хүний хэвийн хэмжээ	Хэвийн размер	Том размер
	36 38 40 42 44 46 48	50 52 54
Цээжний	84 88 92 96 100 104 110	116 122 128
Өндрийн	168 168 168 168 168 168 168	168 168 168
Бэлхүүсний	66 70 74 78 82 86 92	98 104 110
Таазны	91 94 98 102 105 109 114	120 125 131
Бэлхүүснээс хөлийн ул хүртэл хэмжээ	106 106 106 106 106 106 106	106 106 106

5.9. Тусгай зориулалтын хувцас

- 5.9.1. Ногоон байгууламжийн хортон шавж устгах, химийн бодис, шохойтой харьцан ажиллах үед тусгай зориулалтын хувцас хэрэглэнэ.
- 5.9.2. Ажлын тусгай хувцсыг гадуур өмсөх бөгөөд механик үйлчлэл, үрэлт, тостой нөхцөлд өмсөхгүй.
- 5.9.3. Хувцасны материал нь хөдөлгөөний чөлөөт байдлыг хангах, хөнгөн, биед эвтэйхэн шингэн үл нэвтрүүлэх шинж чанартай байна /Зураг 3/.



Зураг 19. Тусгай зориулалтын хувцас (Жишээ зураг)

5.11. Ажлын гуталд тавих шаардлага

5.11.1. Ажлын гутал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- хүйтэнд тэсвэртэй, халтирдаггүй;
- бат бөх;
- цахилгаанд дамжуулдаггүй;
- ус, чийгт тэсвэртэй материалтай;
- хөнгөн, хөдөлгөөнд саадгүй түрийтэй.

5.11.2. Тусгай зориулалттай гутал ба хамгаалалттай гутлын бүтэц **EN ISO20345: 2004** стандартыг хангасан гутал (200Ж энергитэй цохилт болон 15000Н хүчээр үйлчлэхэд тэсвэртэй). **EN ISO 20347: 2004** Үйлдвэрээс шалтгаалах бэртэл гэмтлээс хамгаалах, үйлдвэрийн орчин нөхцөлд тохирсон гутал. Хамрын хатуулга нь ган биш ч цахилгаантай ажиллах үед, ус болон тостой орчинд аль эсхүл төрөл бүрийн химийн бодис ба шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй байна. **SB-200Ж** үйлчлэлд тэсвэртэй мөн **S1, S2, S3, S4, S5**-тэй үзүүлэлтийг хангасан.



Зураг 20.Цэцэрлэгжүүлэлтийн хөдөлмөр хамгааллын гутал (Жишээ зураг)

5.12. Гарын хамгаалалт,бээлий

5.12.1. Гар хамгаалах хэрэгслийг хийц, бүтэц, зориулалтаар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- механик үйлчлэлээс хамгаалах;
- химийн бодисоос хамгаалах;
- дулааны үйлчлэлээс хамгаалах;
- цахилгаан хүчдэлээс хамгаалах;
- доргионоос хамгаалах.

5.12.2. Ерөнхий шаардлага - Гар хамгаалах хэрэгсэл нь энэ стандартад үзүүлсэн тэмдэглэгээ болон MNS 4931: 2000 стандартын шаардлагыг хангасан байна. Үүнд:

- бээлий болон түүний баглаа боодол дээр зориулалт, ашиглалтын зааврыг бичсэн байна;
- бээлийг зориулалтаар нь ашиглахад гарын арьсанд сөрөг нөлөөлөл, цочрол үзүүлэхгүй байна;
- бээлий нь хөнгөн, гар, хурууны хөдөлгөөнд саад учруулахгүйгээр хийгдсэн, эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлагад нийцсэн байна.

6. ОСОЛ ГЭМТЛИЙН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

6.1. Анхны тусламж үзүүлэх дөрвөн шат дараалал байдаг. Үүнд:

- 6.1.1 орчны аюулгүй байдал болон тухайн тусламж шаардлагатай байгаа хүний байдлыг үнэлж, оношилно;
- 6.1.2 ямар төрлийн анхны тусламжийг хэрхэн үзүүлэхээ шуурхай шийдвэрлэж, дэс дарааллаа төлөвлөнө;
- 6.1.3 анхны тусламжийг үзүүлж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ;
- 6.1.4 үзүүлсэн анхны тусламжийн нөлөөг үнэлж дүгнэн, өвчтөний байдлыг анхаарч асарна.

6.2. Осол гэмтлийн үед нөхцөл байдал амархан өөрчлөгдөж, эхний удаа сайн мэдэгдээгүй гэмтэл, өөрчлөлт илэрч болох тул дахин үзэж, шаардлагатай тусламжийг үргэлжлүүлэн үзүүлнэ.

6.3. Анхны тусламжийн хайрцаг, түүний иж бүрдлийн шаардлага


- 6.3.1 Анхны тусламжийн хайрцгийг ажил гүйцэтгэх талбай болон ажлын байранд зохих иж бүрдлийн дагуу байнга бэлэн байлгана.
- 6.3.2 Анхны тусламжийн хайрцагт дараах зүйлс багтсан байх. Үүнд:
 - ариутгасан хөвөн, боолт;
 - цус тогтоогч боолт;
 - хурууны боолт;
 - ариутгасан салфетка;
 - халуун, даралт хэмжигч;
 - чимхүүр, мохоо хайч;
 - үрэвслийн эсрэг эм;
 - хос резинэн бээлий;
 - иодын спиртийн уусмал 5%.



Зураг 21. Анхны тусламжийн хайрцаг
(Жишээ зураг)




Зураг 22. Анхны тусламжийн хэрэгсэл
(Жишээ зураг)



Зураг 23.Артерийн судасны цус алдалтын үед чангалуур тавьж боох (Жишээ зураг)

6.3.3 Үе мөч мултраагүй, яс хугараагүй боловч шархнаас цус алдаж байвал үенд нь хөвөн, бөс даавуу ивж нугалан боож цус тогтоох арга хэмжээ авна.



Зураг 24.Үе мөчний яс хугараагүй боловч шархнаас цус алдаж байх үеийн боолт хийх арга (Жишээ зураг)

Амьсгалын үйл ажиллагаа алдагдсан үед үзүүлэх анхны тусламж



Зураг 25.Залгиурт тээглэсэн гаднын биетийг авах арга (Жишээ зураг)



Зураг 26.Амьсгалын дээд замд ус орсон үед авах арга (Жишээ зураг)



Зураг 27.Амнаас аманд зохиомол амьсгал хийх арга (Жишээ зураг)

7. ЦЭЦЭРЛЭГЧИЙН МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

- 7.1. Цэцэрлэгч нь дараах аюулгүй ажиллагааны зөвлөмжийг мөрдөнө. Үүнд:
- 7.1.1 гүйцэтгэх ажлын нөхцөл, чөлөөтэй хөдлөхөд тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас заавал өмссөн байх (малгай, бээлий, өмд, цамц, гутал, амны хаалт, нүдний шил);
 - 7.1.2 гараа зүсэх, шавжид хазуулах, арьсыг цочроохоос хамгаалахын тулд үргэлж цэцэрлэгжүүлэлтийн бээлий өмсөх;
 - 7.1.3 ажилд зохих багаж, хэрэгслийг зааврын дагуу ашиглах (Жишээлбэл, хүрз эсхүл гар хүрз);
 - 7.1.4 татрангийн эсрэг, ургамлын хачгийн эсрэг вакциныг цаг тухайд нь хамрагдаж байх;
 - 7.1.5 багажийг өөр хоорондоо шидэж дамжуулахгүй байх.
- 7.2. Холимог хөрс бэлтгэх ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны дарааллыг мөрдөж ажиллана. Үүнд:
- 7.2.1 ургамал тарих холимог хөрс бэлтгэхдээ зориулалтын саванд, эсхүл салхины нөлөө багатай нөмөр газар гүйцэтгэх;
 - 7.2.2 хөрсний холимог бэлтгэх ажлыг гүйцэтгэхдээ заавал иштэй багаж (хүрз, тармуур, шор, гэх мэт) ашиглах;
 - 7.2.3 агаар дахь тоосонцрын эрсдэлийг бууруулахын тулд хольцыг бага зэргийн усаар шүршиж норгох;
 - 7.2.4 холимог хөрсийг нам даралтын хоолой ашиглан зөөлөн услах;
 - 7.2.5 холимог хөрсийг богино зайд зөөхдөө хөдөлмөр хөнгөвчилж тэрэг, бага оврын техник ашиглах;
 - 7.2.6 машин бүрэн зогссон үед жолооч зөвшөөрснөөр услах ажлыг эхлүүлэх;
 - 7.2.7 хоолой, шланк авах холбох, хураах ажлыг жолооч гүйцэтгэнэ;
 - 7.2.8 ургамал услахдаа ш50 шланкаар усалж байгаа бол 10 метрээс уртгүй байх, ш25- ш32 шланкаар ургамал усалж байгаа бол 15-20 метрээс уртгүй байх шаардлагатай. хэрэв шланк уртасгах ба голчийн хэмжээ нэмэгдэхэд хоёр дахь ажилчныг хамтарч ажиллуулах шаардлагатай;
 - 7.2.9 усалгааны шланкыг үүрэхгүй байх;
 - 7.2.10 усалгааны шланкыг түрдэг тэрэг, бага оврын техникээр талбай хооронд зөөх;
 - 7.2.11 шланкыг мушгихгүй, хөлд ороохоос хамгаалах;
 - 7.2.12 шүршүүр бороожуулагч, суурь машинаар усалгааг хийх үед хөдөлгүүр ба шахуурт насосыг ажлын байдалд тохируулж байж усалгааг хийх.
- 7.3. Ачиж, буулгах ажил ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө. Үүнд:
- 7.3.1 тээврийн хэрэгсэл бүрэн зогссон үед жолоочийн зөвшөөрлөөр ачиж, буулгах ажлыг эхлэх;
 - 7.3.2 машин, тоног төхөөрөмжийн нөхцөл байдлыг шалгах;
 - 7.3.3 машин, тоног төхөөрөмжийг зөв хэрэглэж байгаа эсэхийг шалгах;

- 7.3.4 тавиур, тавцангийн тогтвортой байдлыг шалгах;
 - 7.3.5 тавиур, тавцан дээрх эд материал аюулгүй хадгалж байгаа эсэхийг шалгах;
 - 7.3.6 ажил гүйцэтгэх явцад дээрээс эд материал унах эрсдэл байгаа эсэхийг шалгах;
 - 7.3.7 халтирч унах, бүдрэх, хөл гараа хавчуулах эрсдэл байгаа эсэх;
 - 7.3.8 хаалт, хашилт, хамгаалалт тавих шаардлагатай эсэхийг тогтоох;
 - 7.3.9 ажил гүйцэтгэж байгаа анхааруулах тэмдгийг байрлуулах.
- 7.4. Ургамал бордох ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө. Үүнд:
- 7.4.1 ажилтан хамгаалалтын ханцуй давсан резинэн бээлий өмсөх ба ажлаа дуусгаад бээлийгээ усаар зайлж угаана;
 - 7.4.2 ургамлын нэгдмэл тэжээлд эрдэс ургамал ба амьтны гаралтай бордоог бэлтгэхдээ зориулалтын саванд, эсхүл нөмөр газар салхинд хийсчихээс хамгаалж хийх;
 - 7.4.3 бордоог бэлтгэх, хийх, савлах ажлыг гүйцэтгэхдээ заавал иштэй багаж (хүрз, тармуур, шор, гэх мэт) ашиглах;
 - 7.4.4 бордоог богино зайд зөөхдөө хөдөлмөр хөнгөвчилж хувин, тэрэг, бага оврын техник ашиглах.
- 7.5 Ургамалд таналт, тайралт хийх ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллана. Үүнд:
- 7.5.1 цэцэрлэгч нь ургамлын өргөс, хатсан мөчир, үзүүртэй ирмэг зэргээс хамгаалсан (савхин, давхар будагтай, берзинтэн аль нэг нь байж болно) бээлий өмсөх;
 - 7.5.2 ургамал танаж тайрах ажлууд нь үзүүртэй, иртэй багажтай харьцах тул гар багажийг зориулалтын (цэцэрлэгчийн) цүнхэнд ирийг хамгаалж, хадгалж явах;
 - 7.5.3 багаж тус бүртэй ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгааг авсан байх.
- 7.6 Мод, сөөг тарих нүх ухах ажлын явцад үүсэж болзошгүй эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зааварчилгаа. Үүнд:
- 7.6.1 мод, сөөгийн нүхийг гараар ухах үед цэцэрлэгчин өөрийн биеийн өндөрт тохирсон иштэй хүрз ашиглах;
 - 7.6.2 хурц иртэй жоотуу, царил ашиглаж байгаа тохиолдолд гараас амархан мултрахгүй иштэй багаж сонгох;
 - 7.6.3 хүрз, жоотуу, лоом, царил ашиглах явцад хүчтэй далайх, цохих үйлдлийг гүйцэтгэхдээ ойролцоо ажиллах хүнээс зай барьсан эсэх, өөрийгөө бүрэн хамгаалсан эсэхийг шалгаж үзэх;
 - 7.6.4 нүх ухах багаж хэрэглэх явцад хад, чулуу их үсрэх аюултай тул цохих, бяцлах үйлдлийг их хүчлэхгүй гүйцэтгэх;


- 7.6.5 төв суурин газар, барилга байгууламж, орон сууцны орчинд нүх ухах явцад цахилгааны утас, шугамын хоолой зэрэг илэрч болзошгүй тул ажлын зурагт тэмдэглэгээ байгаа эсэхийг шалгах;
 - 7.6.6 цахилгааны болон шугамын хоолойн тэмдэглэгээгүй газар ажиллах явцад, цахилгааны утас, шугам, хоолой илэрвэл мод, сөөгийн нүх ухах ажлыг шууд зогсоох.
- 7.7 Цэцэрлэгжүүлэлтэд мод, сөөг суулгах ажлын явцад үүсэж болзошгүй эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө. Үүнд:
- 7.7.1 мод, сөөгийг суулгахдаа технологийн дарааллыг мөрдөж ажиллах;
 - 7.7.2 мод сөөгийг тарихдаа нахиа, мөчир үндсийг гэмтээлгүй суулгах бөгөөд үндэс мөчрийг танах тайрах тохиолдолд зориулалтын хайч, тастагч хэрэглэх;
 - 7.7.3 мод, бут сөөгийн арчилгаанд хэрэглэх гар хайч(секатор) ашиглаагүй үедээ зориулалтын цүнхэнд газар тавих бөгөөд гутлын түрий болон хувцасны халаасанд хийхийг хориглоно;
 - 7.7.4 ажил гүйцэтгэх явцад эргэх, тонгойх үйлдэл хийхдээ ойр байрлах ухсан нүхэнд хий гишгэж гэмтээхээс болгоомжлох;
 - 7.7.5 мод, сөөгийг суулгахдаа иш, мөчирт нүд, нүүрээ хатгах, шүргэхээс болгоомжилж, суганд хавчуулах, титмийн хэсгийг нэг гараараа дарах маягаар өөрөөсөө тусгаарлаж ажиллах;
 - 7.7.6 тарих модыг хүний хөлд тээглэхгүй, нүхний амсарт юм уу, нүхэн дотор түр байрлуулах.
- 7.8 Тээвэрлэх, ачиж, буулгах, хадгалахад дараах зааварчилгааг мөрдөнө. Үүнд:
- 7.8.1 машин тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн ажлын зааварчилгааг авах;
 - 7.8.2 үндэс, титэм хамгаалсан мод, сөөгийг ачихдаа 25кг хүртэл жинтэй багцыг цэцэрлэгч үүрч, тэвэрч зөөх;
 - 7.8.3 25 кг-аас дээш жинтэй модыг ачихдаа бэхлэгчтэй өргөгч машин ашиглах;
 - 7.8.4 модыг ачиж буулгах үед тавцан дээрээс хий гишгэх, халтирах, унах аюулаас болгоомжилж ажиллана.
- 7.9 Хамгаалагдсан хөрсөнд болон ил талбайд нэг ба олон наст цэцгийг үр, булцуугаар үржүүлэхэд дараах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө Үүнд:
- 7.9.1 хүлэмжийн нөхцөлд ажиллах үед түрийтэй гутал, урт ханцуйтай бээлий, биед чөлөөтэй хөдлөхөд хөнгөн хувцас өмсөх;
 - 7.9.2 цэцгийн үр булцууг тарихдаа идэвхжүүлэгч, ариутгагч зэргийг ашиглахдаа амны хаалт хэрэглэх;
 - 7.9.3 “гар багажтай ажиллах” үеийн аюулгүй ажиллагааны болон ногоон байгууламжийн арчилгааны үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах;
 - 7.9.4 хүлэмжид ажиллахдаа цэцэрлэгчийн сандал байнга ашиглах;
 - 7.9.5 усалгаа хийгдсэн буюу хийх үед, усны гуталтай ажиллах;
 - 7.9.6 ургамал хамгаалах, өвчин хортонтой тэмцэх зорилгоор тусгай бодис хэрэглэсэн үед хүлэмжид ажиллахгүй байх.



Зураг 28. Цэцэрлэгчийн сууж ажил гүйцэтгэхэд ашиглагдах сандал (Жишээ зураг)



Зураг 29. Мод сөөгийг хэлбэржүүлэх танах (Жишээ зураг)



Зураг 30.Цэвэрлэгээний огтлол (Жишээ зураг)

7.10. Гар багажтай ажиллах өдөр тутмын ажлын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө.(хүрз, тармуур, алх, сүх, хөрөө, гар хадуур, мөчрийн хайч, бахь)
Үүнд:

- 7.10.1. ажилд гарахдаа зориулалтын хувцас хэрэгслийг бүрэн өмссөн байх;
- 7.10.2 мөчир огтлох, мод тайрах үед ойр орчмын өвс ургамлыг сайтар цэвэрлэж харагдах байдлыг чөлөөтэй болгож ажиллах;
- 7.10.3 хэрэглэгдэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эд ангиудыг бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж ашиглах;
- 7.10.4 багаж хэрэгслийг шидэж дамжуулж болохгүй. багажийг дамжуулах тохиолдолд гараас гарт дамжуулах буюу шал болон найдвартай гадаргад тавих;
- 7.10.5 хөрөө, өрөм, трактор болон бусад дуу чимээ ихтэй багажтай харьцахдаа сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглэх;
- 7.10.6 мөчир огтлох, мод тайрах мэт ажил гүйцэтгэх үедээ хурц үзүүр ирмэгтэй зүйлд ойртох, тухайн ажлын явцад тоос шороо хөдлөх учир битүү нүдний шил зүүх;
- 7.10.7 огтлох, тайрах багажаар ажиллах үед хөл, гар зүсэх, цавчихаас урьдчилан сэргийлж зөв дарааллаар ажиллаж байх.



Зураг 31.Гар багаж ашиглах үед (Жишээ зураг)



Зураг 32.Багажийг ирлэх, ир солих (Жишээ зураг)


7.10.8. Багажны бариул нь их биедээ найдвартай бэхлэгдсэн эсэх, ирмэг, өнцгийн бүрэн бүтэн байдлыг сайтар нягтлан шалгах;




Зураг 33.Хурц ирмэг, иртэй багаж, хэрэгслийн (Жишээ зураг)

7.11. Моторт хөдөлгүүртэй багажаар ажиллах үед дараах аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө. Үүнд:

- 7.11.1. багажийн тохиргоог зааврын дагуу хийж гүйцэтгэсэн байх;
- 7.11.2. багаж хариуцан авч ажиллах цэцэрлэгчин нь багажийн тохиргоо хийх, ажиллуулах дарааллыг сургалтаар авсан байх;
- 7.11.3. багажийг үүрч, түрж, унаж хэрэглэх үед нэмэлт хувцас, тоноглолыг хэрэглэх (бүс, нүдний шил, малгай гэх мэт) ;
- 7.11.4. багажийн ирийн эргэлтээс цэцэрлэгчин биеэ хамгаалж салхинд амархан хийсдэггүй материалтай өмд өмссөн байх;
- 7.11.5. цаг уурын нөхцөлт тохируулж цэцэрлэгчин өөрийн биеийг салхин талд, багажийг салхины чиглэлийн эсрэг талдаа байрлуулж ажиллана;
- 7.11.6. багаж нь шатах материалаар ажиллах галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах;
- 7.11.7. моторт багажаар ажиллах үед ажлын талбайн норм баримталж бусдыг гэмтээхгүй байх;
- 7.11.8. багажны ир солих, засварлах үед ажлын талбараас тусгай аюулгүй цэгт багаж угсрах зааврын дагуу ажиллах.



Зураг 34.Багажийг үүрч, түрж явах
(Жишээ зураг)



Зураг 35.Багажийн ирийн эргэлт
(Жишээ зураг)



Зураг 36.Ажлын талбайн норм баримталж бусдыг гэмтээхгүй бай (Жишээ зураг)

8. ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН НӨХЦӨЛ

8.1. Цэцэрлэгч ажиллахад тохиромжгүй цаг агаарын нөхцөлийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 6.Хаврын улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл

Сар	Хийгдэх ажил	Цаг агаарын тохиромжгүй нөхцөл
III	<ul style="list-style-type: none"> • Үр тарих • Цэцэрлэгт цэвэрлэгээний огтлолт хийх • Өвчин, хортон шавжаас урьдчилан сэргийлэх • Эрт тарьсан ургамал арчлах • Залгагдах болон тарих мөчир бэлтгэх • Хүлэмжийн бэлтгэх ажил эхлэх • Талбайн цэвэрлэгээ хийх • Мод, сөөг цаслах • Мэрэгчдийг хянаж эхлэх 	Ургамал ургахад цаг уурын тохиромжгүй буюу +4°C- аас бага дулаантай байна
IV	<ul style="list-style-type: none"> • Хөрс боловсруулах • Үрийг соёолуулах • Хөл ургамал хянаж эхлэх • Хортон шавж, өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх • Мод, сөөгийн суулгац тарьж эхлэх • Мод, бутыг тайрах • Ногоон байгууламжийн усалгаа эхэлнэ. 	Хуурай салхитай, шороон шуургатай, хуурайшилт их үүснэ.
V	<ul style="list-style-type: none"> • Мод, сөөгийн суулгац, үр, мөчир тарих • Мод үржүүлгийн ажлууд хийгдэж дуусгах • Мод, сөөгийг ухаж бэлтгэх • Талбай цэвэрлэх, тарилтын талбай бэлтгэх • Зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэх, цэцгийн мандал бэлтгэх • Ургамал бордох • Ногоон байгууламжийн усалгааны ажлыг жигдрүүлэн бусад арчилгааны ажлууд хийгдэнэ. 	Хуурай салхитай, шороон шуургатай, хуурайшилт их үүснэ.

Хүснэгт 7. Зуны улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл

Сар	Хийгдэх ажил	Цаг агаарын тохиромжгүй нөхцөл
VI	<ul style="list-style-type: none"> Цэцгийн мандал байгуулах Ногоон байгууламжийн арчилгааны ажлуудыг жигдрүүлэх Зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэх Мод, сөөг хэлбэржүүлэх Хөл ургамалтай тэмцэх Ургамлын өвчин хортонтой тэмцэх 	Халууны улирал эхлэх тул нарших болон харшлын эх үүсвэрүүд нөлөөлж эхэлнэ.
VII	<ul style="list-style-type: none"> Ногоон байгууламжийн арчилгааны ажлуудыг гүйцэтгэх Зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэх Зүлэгт талбайг хадах Хөл ургамалтай тэмцэх Ургамлын өвчин хортонтой тэмцэх Ногоон мөчир бэлтгэх, тарих, арчлах 	Хөрсөн дээрх хүчтэй халалт, аадар бороо орох, үер усны аюул үүсэж болзошгүй цаг хугацаа.
VIII	<ul style="list-style-type: none"> Мод, сөөгийн үр түүж бэлтгэнэ Ногоон байгууламжийн арчилгааны ажил үргэлжилнэ Хөл ургамалтай тэмцэх, зүлэгжүүлсэн талбайг хадах Өвчин хортонтой тэмцэх 	Цаг агаар өглөө орой сэрүүн болж борооны улирал үргэлжилдэг

Хүснэгт 8. Намрын улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл

Сар	Хийгдэх ажил	Цаг агаарын тохиромжгүй нөхцөл
IX	<ul style="list-style-type: none"> Ногоон байгууламжийн талбайг самнаж цэвэрлэх Мод, сөөгийг тарилтад бэлтгэх Хөрс, бордоо бэлтгэх Ургамал бордох Ургамал шилжүүлэн суулгах Мод, сөөгийн үр түүж бэлтгэх, цэвэрлэх 	Цаг уурын сэрүүний нөхцөл бий болно
X	<ul style="list-style-type: none"> Мод, сөөгийг үр, суулгацаар Тарих, шилжүүлэн суулгах, бордох Хөрс бэлтгэх, нөөцлөх Мод сөөгийн усалгааг хийх Модны тогоонд хүлэрт хөрсөөр хучлага хийж өгнө. Өвлийн бэлтгэл ажлууд хийгдэнэ 	Цаг агаар хүйтэрч, салхины эрч ширүүсэх үе
XI	<ul style="list-style-type: none"> Талбайг цэвэрлэнэ Мод, сөөгт цасаар маналт хийж өгнө. Мод, сөөгийг дулаална Мэрэгчдийг анхаарах үе Мод, сөөгийг дулаална 	Цаг агаар хүйтэрч, цас орж хүйтний эрч чангарна.

Хүснэгт 9.Өвлийн улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл

Сар	Хийгдэх ажил	Цаг агаарын тохиромжгүй нөхцөл
XII, I, II	<ul style="list-style-type: none"> Зам талбайн цэвэрлэгээ Мод, сөөгт цас хуримтлуулах Үр тарилтад бэлтгэх 	Хүйтний эрч чангарч, цас орж их хэмжээгээр орно.

9. ЦЭЦЭРЛЭГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, албан байгууллагын цэцэрлэгчийн хөдөлмөр, аюулгүй ажиллагааны шалгуур үзүүлэлт (хүснэгт 9.1)-ийн шаардлагыг хангаж буйг хянаж шалгана.

Хүснэгт 10.Цэцэрлэгчийн хөдөлмөр, аюулгүй ажиллагааны шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Байгууллагын удирдлага, ХАБЭА-н мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журам батлуулан, мөрдөж ажилладаг эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтад техникч, цэцэрлэгчин, ажилтан нарыг хамруулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Хөдөлмөр хамгааллын хувцсанд тавих ерөнхий шаардлагыг биелүүлсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Хөдөлмөр хамгааллын хувцасны ашиглалтын хугацааг тогтоож мөрдөх эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Анхны тусламжийн иж бүрдэлтэй хайрцаг ашиглаж байгаа Эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн, анхны тусламжуудын мэдээлэл танилцуулах самбар байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэгчийн ажлын байранд тавих ахуйн шаардлага бүрэн хангагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэгчид ажил тус бүр дээр аюулгүй ажиллагааны зааварчилгааг бүрэн өгч, бүртгэл хөтөлдөг эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Цэцэрлэгчийн хөдөлмөр, аюулгүй ажиллагааны бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол "Тийм" шаардлага хангаагүй бол "Үгүй" хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монголын Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн үлгэрчилсэн жагсаалт батлах тухай
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал
- MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага
- MNS 5622-2006 Гарын хамгаалалт (бээлий)
- MNS 5623-2006 Хөлийн хамгаалалт ажлын тусгай гутал
- MNS 5621-2006 Толгой хамгаалах хэрэгсэл дуулга
- MNS 4931-2000 Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага
- MNS 13688-2000 Ажлын тусгай хувцас ерөнхий шаардлага
- MNS 3306-91 Сонсголын эрхтнийг хамгаалах нэг бүрийн хэрэгсэл
- MNS 5388-2004 Толгой хамгаалах хэрэгсэл сонсгол хамгаалах хэрэгсэл
- MNS 5389-2004 Нүд хамгаалах хэрэгсэл нүдний шил чихэвч, бөглөө зэрэг хэрэгцээт стандартууд.
- MNS ISO 1835 -3:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. 1м²-ийн жин тодорхойлох арга
- MNS ISO 1835 -4:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга
- MNS ISO 1835 -5:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээсний нягт тодорхойлох арга
- MNS ISO 1835-6:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац суналт
- MNS ISO 1835-7:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тодорхойлох арга
- MNS ISO 1835 -9:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга
- MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага
- MNS ISO 4010:97 Цэвэр ба хагас ноосон ээрмэл даавуу. Ноосны агуулгыг тодорхойлох арга
- MNS ISO 4072: 1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг угаалгад тодорхойлох арга.
- MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга
- MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хуурай нойтон байдал үрэлтэд тодорхойлох арга
- MNS 4010-2009 Ширхэгтийн бүрэлдэхүүн.
- ISO 105 Нэхмэл бүтээгдэхүүний өнгө тогтворжилтын сорилт
- ISO 317:1995 Машинаар хуурайгаар нь цэвэрлэх үед хэмжээний өөрчлөлтийг тогтоох.
- ISO 3635 Хувцасны хэмжээний тэмдэглэгээ-хэмжээг тодорхойлох ба авах
- ISO 3758 Нэхмэл бүтээгдэхүүн –хэрэглэгчдэд зориулсан тэмдгийг шошгод кодлох
- ISO 9237 Агаар нэвтрүүлэлт, агаарын эзлэхүүн, агаарын хэмжээ
- ISO 12947-2 Элэгдэл тэсвэрлэлт
- ISO 105 Нэхмэл бүтээгдэхүүний өнгө тогтворжилтын сорилт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТЭМДЭГ



Зураг 1. Унах аюултай
(Жишээ зураг)



Зураг 2. Ургамал тастаж
болохгүй (Жишээ зураг)



Зураг 3. Авир ч болохгүй
(Жишээ зураг)



Зураг 4. Зүлэг дээр гишгэж
болохгүй (Жишээ зураг)



Зураг 5. Ил гал гарах аюултай
(Жишээ зураг)



Зураг 6. Амны хаалт зүүх
(Жишээ зураг)



Зураг 7. Будагтай
(Жишээ зураг)



Зураг 8. Мод тарьж байна
(Жишээ зураг)



Зураг 9. Өргөстэй, гар хүрж
болохгүй (Жишээ зураг)



Зураг 10. Усалгаа хийгдэж
байна (Жишээ зураг)



Зураг 11. Хашаа давж болохгүй
(Жишээ зураг)

ХАВСРАЛТ 2.

ЦЭЦЭРЛЭГЧИНД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ГЭМТЭЛ




Зураг 1. Биеийн хөлдсөн хэсгийг усанд дүрэх (Жишээ зураг)




Зураг 2. Бүх биеийг дулаацуулах (Жишээ зураг)




Зураг 3. Хүйтний улиралд биеийн захын хэсгүүд болох чих, хамар, хацар, эрүү, гар, хөлийн үзүүрийн хөлдөлтүүд (Жишээ зураг)




Зураг 4. Халууны цохилтод орох (Жишээ зураг)



Зураг 5.Цахилгааны эрчим хүчний эх үүсвэрт цохиулсан үед аврах арга хэмжээний (Жишээ зураг)



Зураг 6.Түлэгдэлтийн зэргээс хамаарах тусламжийн арга хэмжээнүүдийн (Жишээ зураг)



Зураг 7.Хамрын цус алдалтанд зөв арга хэмжээг авах (Жишээ зураг)

ТЭМДЭГЛЭЛ

Blank page with horizontal dotted lines for writing.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар